

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Увс аймгийн Аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3, 18-р зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитыг СТАУС программд бүрэн нэвтрүүлэх зорилт тавьж ажилласныг амжилттай хэрэгжүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 19, төсвийн шууд захирагч 52, төрийн өмчийн үйлдвэрийн газар 3, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж 4, засгийн газрын болон орон нутгийн тусгай сан 6, нийт 85 байгууллагад дүгнэлт өгч, 116 төсөвт байгуулагыг түүвэрт хамрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 79 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй, 5 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 байгууллагын санхүүгийн тайланд сөрөг санал дүгнэлтийг тус тус өглөө.

Аудитаар нийт 11.5 тэрбум төгрөгийн 180 алдаа зөрчил илрүүлснээс зөрчлийг арилгуулахаар 5.1 тэрбум төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 84.9 сая төгрөгийн 26 акт тогтоож, аудитын явцад 2.6 тэрбум төгрөгийн 101 алдааг санхүүгийн тайланд залруулж, 3.0 тэрбум төгрөгийн 38 алдаа зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсох зөвлөмж өглөө.

Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д “Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, **санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан**, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан төсвийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллалаа.

УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР